



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 7/03


Улаанбаатар хот

### Г Улаанбаатар хотын гүйлтийн тэшүүрийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах гүйлтийн тэшүүрийн тэмцээнийг 2018 оны 01 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд Хадгайтын мөсөн гулгуурын талбайд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.618.000 /нэг сая зургаан зуун арван найман мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг мэргэжилтэн /Э.Мөнх-Эрдэнэ /-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500020

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны  
даргын 2018 оны 07-р сарын 28-ны өдрийн  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын 2018 оны гүйлтийн тэшүүрийн аварга  
шалгаруулах тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 12 x 20.000 төг = 240.000 төг 12 x 15.000 төг = 180.000 төг 12 x 10.000 төг = 120.000 төг	520.000
2.	Шүүгчдийн ажлын хөлс: /15 хүн x 2 өдөр x 20.000 төг/	600.000
3.	Диплом, өргөмжлөл	50.000
4.	Медаль:	288.000
5.	Анонс /цом / бичлэг	60.000
6.	Үкель урлаг спортын тоглолт, тайз чимэглэл	100.000
<b>Нийт дүн</b>		<b>1.618.000</b>

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2018 оны... сарын ...-ны өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Улаанбаатар хотын 2018 оны гүйлтийн тэшүүрийн аварга тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүн

- |                       |               |
|-----------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч      | С.Мөнхдэлгэр  |
| 2. Нарийн бичиг шүүгч | Л.Нацагдорж   |
| 3. Нарийн бичиг шүүгч | Н.Батбаатар   |
| 4. Эмч шүүгч          | Ё.Энхтайван   |
| 5. Шүүгч              | Г.Болд        |
| 6. Шүүгч              | Б.Цэрэндолгор |
| 7. Шүүгч              | Б.Баясгалан   |
| 8. Шүүгч              | Ш.Мөнх-Эрдэнэ |
| 9. Шугамын шүүгч      | С.Отгонбаатар |
| 10. Шугамын шүүгч     | Б.Батсайхан   |
| 11. Шугамын шүүгч     | М.Цогзолмаа   |
| 12. Шугамын шүүгч     | У.Мягмарсүрэн |
| 13. Шугамын шүүгч     | А.Амгалан     |
| 14. Шугамын шүүгч     | У.Нарантуяа   |
| 15. Шугамын шүүгч     | С.Удвал       |